

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXV (367)

2012

(234-239)

НОЁН ХУТАГТ ДУЛДУЙТЫН РАВЖААГИЙН
“ҮЛЭМЖИЙН ЧАНАР” ДУУНЫ ТУХАЙД

Б.Хишигсүх*

Монголын сонгодог уран зохиолын судалгааны хүрээнд Ноён хутагт Данзанравжаагийн бүтээл туурвилын судалгааны асуудал чухал байр суурийг эзэлдэг билээ. Зуун дамнан “ардын дуу” хэмээгдэх болтлоо уламжлагдсан “*Үлэмжийн чанар*” дуу бол бүсгүй хүний гоо үзэсгэлэнг хүслийн таван эрдэм буюу нүднээ харагдах дүрс, чихээр сонсох дуу, хэлээр мэдрэх амт, биеэр хүртэх хүрэлцэхүй гэсэн таван мэдрэхүйн үүднээс утга төгс, уран яруу магтан дуулсан алдартай дуу болно. Уг дуу нь, орчлонд шунахуйн үүд болсон хүслийн таван эрдмийг тэвчин хазаарлаж, нүд, чих, хамар, бие, хэлийн таван хаалгыг хааж, бодь мөрийг хичээхүйн аргыг дотоод сэтгэлдээ бясалгаж “*Уданаварга*” буюу “*Зориуд өгүүлэхүйн цоморлиг*”-т өгүүлсэнчлэн:

Алмайран харагч нүдийг боомтлох нь сайн
Авианд алгасрагч чихийг боомтлох нь сайн
Анхилах үнэрч хамрыг боомтлох нь сайн
Амтлан шунагч хэлийг боомтлох нь сайн ...

хэмээн орчлонгоос эгээрэхийг сургасан буддын шашины номлолыг эсрэгцүүлэн, харин ч хүслийн таван хаалгыг хүмүүний ертөнц рүү чөлөөтэй нээж, үзэсгэлэнт бүсгүйн дүрийг хүслийн таван эрдмийн үүднээс нүдэнд харагдаж, сэтгэлд хоногштол дүрсэлсэн нь нэг талаас даян буддизмыг баримтлагч Ноён хутагтын дорно дахины утга, соёлын далай гүн мэдлэг, суу билгийн үүднээс өгүүлсэн болох нь тодорхой билээ.

“*Үлэмжийн чанар*” дууг зохиох болсон тухайд өгүүлсэн цөөнгүй домгийн хувилбарууд бий. Энэ тухайд эрдэмтэн, судлаач Л.Хүрэлбаатар өгүүлэхдээ: “Хутагтын бие чилээрхэхэд, засал болгож хийдэг байсан “*Дагинасыг хашираах хариулгын горим*” нэртэй, одоо гүрэм золигийн зан үйл гэхээсээ дуулалт бүжгэн жүжгийн тайзны засал юм уу, найруулагчийн төлөвлөгөө ч гэж үзэхээр нэгэн сонин дэвтэр буй, тэр дэвтэрт “Энэ тахил нь хүслийн таван эрдмийн үүднээс Ноён хутагтыг магтсан байх бөгөөд “*Сэргэлэн зант цагаан*” дууны аятай байна.” гээд, золигт гарах зан үйлийн тухай, ... Эгэлийн хувцас үл өмссөн таван дагинас хүрч ирээд, ... Хутагтын нэрийг гурвантаа урин дуудаад, “Аяа, энд мань (бидний) ирсэн хэргийн гол болбоос, энэ өдөр дагинасын их дүйцэн хорин тавны өдрөө, өрнө зүгийн “*Удияанын*” (Үржинхандын орон) оронд

* МУИС-ийн МХСС-ийн Утга зохиол судлалын тэнхим

таныг залаар ирбэй бидэн, таны хүмүний оронд суух насны хэмжээ, үйлийн хувь бүхэн төгссөний тулд, эдүгээ ану баруун зүгийн Үржинхандын оронд магад өөд болох хэрэгтэй байнам. Бид дагинасууд угтуулчаар угтаж байнам. Өөд болон очмуй.” гээд тэд бүгд Ноён хутагтыг шууд бүчин гараад, аяа бид лам эрдэнийгээ залмуй. Шүхэр манжлага, хөгжим бэлтгэгтүн.”, “Энэ зуур Ноён хутагтын хувцас тэргүүтнээр чимсэн нэг дэрсэн хүнийг дамнуургаар золио болгон хуурч өгч явуулна.” (162, 163) хэмээн бичсэнийг энд дурджээ. Тэгвэл уг зан үйл нь Монголчуудын дунд эртнээс уламжлалтай бөгөөд “Монголын Нууц Товчоо” зохиолд “Өгэдэй хааны бие чилээрхэхэд, ойр дотны (алтан ургийн) хүний амь хэрэгтэй, хэмээн бөө нар айлддаг ба Тули амиа өргөснөөр Өгэдэйн бие илааршдаг.” (272) хэмээх өгүүлэмж бас бий. Харин ийм зан үйлийг буддын шашины зан үйлд “сор залах” гэдэг. Энэхүү “Үлэмжийн чанар” хэмээх дууны хувьд олон асуудлууд нууц хэвээр байна. Тухайлбал, Ноён хутагт уг дууг ямар зорилгоор бичсэн болох, Дадишури хэмээх бүсгүйд зориулж зохиосон эсэх, Дадишури тэргүүтэн таван хандо Ноён хутагтын лагшинг чилээрхэхэд зохиож өргөсөн эсэх зэрэг болно. Ноён хутагтын “Таван тахилын дуу” хэмээн алдаршсан “Үлэмжийн чанар” дуу нь Равжаагийн лагшин чилээрхсэн үед Удияанын орон буюу Үржинхандын орны таван хандо хөх, улаан, ногоон, цагаан, шар өмсгөл тэргүүтнийг асаасан Доржханд, Ринчинханд, Бадамханд, Лайжинханд, Санжайханд хэмээх таван дагинасын өргөсөн дуулал юм, хэмээх домог эдүгээг хүртэл хэлцэгдсээр ирсэн билээ. Энэхүү тахилын дуу нь додъёна буюу хүслийн таван эрдмийн үүднээс “Ноён хутагтыг магтсан” магтаал (2006.80) ажээ.

Ноён хутагтын “*Үлэмжийн чанар*” дууны талаар шүлгийн нь гоо зүй, урлагийн талаас нь, арга, билгийн үүднээс нь, туурвил зүй нь асуудлаар тус тус задалж үзэхийг зорьсон болно.

“Үлэмжийн чанар” дууны амин сүнс нь шүлгийн нь уран сайхан юм.

Нэгдүгээрт: Шүлгийн бадаглал зүй. Тус бүр нь таван шад бүхий таван бадгаас бүрдсэн, дөрвөн бадгийн сүүлийн шадад “зээ” хэмээх аялга үгийг оодон холбоцоор “хашиж” төгсгөсөн байгаа нь өвөрмөц төдийгүй “”зээ хөө, зээ, мину зээ” зэрэг аялга, сул үгсийг түлхүү хэрэглэсэн байдаг нь айзам хэмнэл нэн тохирдгоос гадна ардын дууны аяс намбыг шингээсэн байна. Үүнд,

Нэгдүгээр бадагт: ...Үнэхээр сэтгэлийг хөдөлгөнө зээ

Хоёрдугаар бадагт: ...Хөөрхөн аалыт мину зээ

Гуравдугаар бадагт: ...Улмаар сэтгэлийг хөдөлгөнөм зээ

Дөрөвдүгээр бадагт: ...Баярыг улам арвитгана зээ..., хэмээжээ.

Хоёрдугаарт: Монгол шүлгийн уламжлалт зарчимын нэг болох “толгой холбох” зарчмыг ягштал баримталсан байна. Шүлгийн бадгийн хувьд үеийн тоо харилцан адилгүй байх бөгөөд дөрвөөс арван үетэй байна. Энэ нь самгарди хэлний болон үет хэлний шүлгийн үе, өлмий тааруулан бичих Дорно дахины уламжлалыг хадгалсан явдал юм.

Гуравдугаарт: Монголын эртний уран зохиолын хөгжилд гүн ухааны санааг уран сайхны төгс төгөлдөр дүрслэлээр хослуулан дүрсэлж, барилдуулан зохиох “дуун шалгадгийн соёо хумсыг зөрөлдүүлэх” хэмээх уламжлал бий билээ. Учир нь “ ... арслангийн хурц хумс барын бөгсөн талыг хааж, барын хурц соёо арслангийн цээжин

талыг хааж, цээж бөгсөө зөрүүлэн хэвтсэн арслан бар хоёрын хүчин чадал дөрвөлжилж, араатны манлай, жигүүртний хаан аль нь ч тэр хоёрын аль ч талаас нь халдаж чадахгүй болдгийн адил..”(боть 56.186) хэмээн өгүүлсэнчлэн гүн ухааны үндэс, уран сайхны дүрслэл хоёрыг төгс хослуулж шүлэг зохиол туурвих ёстой гэсэн санаа болно. “Үлэмжийн чанар” дууны шүлгийг авч үзвэл: Бүсүй хүний гоо үзэсгэлэнг хоосон магталгүйгээр хүслийн таван эрдмийн үүднээс:

Үлэмжийн чанар төгөлдөр

Өнгө тунамал толь шиг

Үзэсгэлэнт царайг чинь

Үзвэл лагшин төгс маань

Үнэхээр сэтгэлийг булаанам зээ..., хэмээхэд шүлгийн эхний бадагт: орь залуугийн өнгө төгс, тунамал сайхан царайг нүдээр харахын урам сэргэх буюу төрх байдлаар мэдрэхүйн бодит үнэнийг өгүүлсэн бол,

Хөшүүн сэтгэлийг уяруулагч

Хөхөө шувууны эгшиг шиг

Хөөрхөн эелдэг үг чинь

Хүүрнэн суухад урамтай

Хөөрхөн аалт мину зээ..., хэмээхэд дүрсээр мэдрэхүйн үндсэн дээр хөхөө шувуун эгшиг мэт уянгалаг хоолойг чихээр сонсох баясал төрж буйг, угтаа бол ая дуу гэдэг хүний сэтгэлийг хөдөлгөгч гэсэн санааг дууны мэдрэхүйгээр харуулснаараа бодитойгоос хийсвэр лүү хандуулж улмаар,

Учирмагц сэнгэсэн

Уран гол шиг бие чинь

Угаас хамт бүтсэн

Улаан занданы үнэр шиг

Улмаар сэтгэлийг хөдөлгөнөм зээ..., хэмээсэн гуравдугаар бадагт: дүрслэлийг бүр наашлуулж, улаан занданы мэт сайхан үнэрийг хамраар үнэрлэх хүсэл оргилж буйг хийсвэрээс хийсвэр лүү нарийн хандуулж,

Бадмын дундаас дэвэрсэн

Балын амт адил

Баясгалант ааль чинь

Багдаж ханашгүй

Баярыг улам арвитгана зээ..., хэмээсэн дөрөвдүгээр бадагт: алслалыг дүрслэхдээ балын амт мэт уруулыг хэлээр амтлах хүсэл бадрах буюу амтлах мэдрэхүйгээр ойртуулан өгүүлсэн бөгөөд,

Хүний энэ насанд

Хүссэн хэргээ бүтээгээд

Хүсэлт тэнгэрийн эдлэл мэт

Хөлгүй жаргалын далайд

Хөвж хамт жаргая..., хэмээсэн тавдугаар бадагт: бурхан, тэнгэрээс оногдсон хувь тавилангаа эдлээд, жаргах тухай өгүүлэхдээ өмнөх бадагтай харьцуулж үзвэл харьцангуй бодитой гэмээр хийсвэрээс бодитой руу, өөрөөр хэлвэл үзэсгэлэнт бүсгүйн зөөлөн цагаан биеийг хүрэлцэн хүртэх хүсэл төрдөг хүний орчлонгийн явдлыг учир шалтгааны нарийн дэс дараатайгаар бадаг бүрээр дамжин гарч байгаа утга санааг улам бүр гүйцээн урлаж, төгс төгөлдөр болгосон байна.

Дөрөвдүгээрт: Дандины “Зохист аялгууны толь”-ийн утгын чимгүүдийн тухайд тавдугаар Далай лам Лувсанжамц өгүүлэхдээ: “Хүслийн таван эрдэм буюу дүрс, дуу, амт, үнэр, хүрэлцэхүй тавыг тус бүр үгийн чимэг болгон магтаж болно.” (186) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Тэгвэл “Зохист аялгууны толь”-ийн “Утгын гучин таван чимэг” дэхь “Өвөр чанарыг өгүүлэх” чимэг нь дараах дөрвөн зүйлд хуваагддаг. Үүнд,

Нэгдүгээрт: Язгуур буюу дүрсийн чимэг нь оршин ахуйн язгуур буюу хэв шинжит нөхцөл байдалд нь өгүүлэх.

Хоёрдугаарт: Үйлдэх үйлсийн чимэг нь хөгжил хувьсалд өгүүлэх.

Гуравдугаарт: Эрдэм буюу чадлын чимэг нь учир утгыг гаргаж өгүүлэх.

Дөрөвдүгээрт: Эдийн чимэг нь онцлог мөн чанарыг өгүүлэх зэрэг болно. Өөрөөр хэлвэл аль нэгэн байдлаар хэтрүүлэн гүтгэлгүй, ямар нэг үзэл санаагаар нууцлан далдалсан бус, бодитой тодорхойгоор нь өгүүлэхийг туйлаас эрхэмлэнэ гэсэн үг билээ. Дээрхээс “Эрдэм буюу чадлыг үзүүлсэн чимэг”-ийн зарчимаар хүслийн таван эрдмийг магтан дуулдаг бөгөөд Ноён хутагтын “Үлэмжийн чанар” дууны шүлгийн хувьд гэвэл өвөр чанарыг өгүүлэх утгын чимгийн зарчимаар бичигдсэн хэмээн үзэж байна.

Ийнхүү өвөр чанарыг өгүүлэх утгын чимгийн зарчимыг онолын үүднээс авч тайлбарлавал:

Нэгдүгээрт: Бүсгүй хүнийг язгуурын талаас нь үлгэрлэхдээ үзэсгэлэнт царай, эелдэг хоолой, тансаг үнэр, улаан уруул, голшиг уран турьхан биеийн нийтлэг чанарыг,

Хоёрдугаарт: Үйлс буюу хөгжил хувьслын талаас нь таван мэдрэхүйгээрээ бүсгүй хүний өвөр чанарыг мэдрэхийн учрыг,

Гуравдугаарт: Эрдэм буюу учир утгыг гаргахын учир нь толь шиг царай, хөхөө шувууны эгшиг шиг дуу хоолой, агар занданы анхилам үнэр, балын амт лугаа уруул, уран гол шиг бие тэргүүтнийг өгүүлэх,

Дөрөвдүгээрт: Эд буюу онцлог чанарыг нээн өгүүлэхийн учир нь өвөр чанарыг мэдрэхүйн таван эрхтний үүднээс урнаар магтан дуулж эр хүний хүслийг гижигдэх орь залуугийн цог заль төгссөн бие цогц, зүс царай, дуу хоолой, үнэр, амт зэргийг ийн магтан дуулсан,

Тавдугаарт: Дорно дахин Энэтхэг, Төвдийн уламжлалт уран уран дүрслэлийн хэрэглүүр болох “улаан занданы үнэр”, “балын амт”, “шувууны уянгалаг эгшиг” зэргийг авч баяжуулсан байгаа нь эрхгүй ханчин ханбо С.Жамъянгаравын өгүүлсэнчилэн:

... Дамбарын бэлхүүст баясгалант эхийн биетэй
Замбагын цэцгийн өнгө туяат хацартай
Бямбын уруул сувдан эрихэн шүдтэй
Замбын газрын шижир алтан чимэгтэй ...,
Баялаг хүслийн элч – хөхөөн яруухан дуунд
Баясаж шимийг баригч – залуу модон цохилно
Балт цэцгэнд согтогч – зөгийн цэнгэл наадамд
Балчигийн уснаас төрөгч – лянхуа шимээн хүртээмүй. (310) хэмээн урнаар шүлэглэсэн хийгээд эсвэл,

... Царай сайт чиний жавхлант гоо дүрс мэт
Цамбын энэ охин сэтгэлд үнэхээр зохистой
Гандирын ятга яруу зөөлөн дуугардгаараа

Галбингаагийн уран дуутай тэнцэх хань олов..., хэмээсэн шадуудыг эрхгүй санагдуулж байна.

Ноён хутагтын “Үлэмжийн чанар” дуунд үзэгдэх хэлбэрээс хүртэж мэдрэх мэдрэмжээр дамжуулж хүрэлцэн хүртэх шунахуйн хүсэл төрдөг хүний орчлонгийн учир шалтгааныг ийн урнаар шүлэглэсэн дүрслэлийг дараах байдлаар томъёолж болохоор байна. Үүнд, **(Бодит – хийсвэр – хийсвэр – хийсвэр – бодит буюу ерөнхий – тусгай – тусгай – тусгай – ерөнхий)** гэж үзэж байна. Өөрөөр хэлвэл, **((өнгө тунамал царай (бодит) – хөхөөн эгшиг шиг дуу хоолойн өнгө (хийсвэр) – учирмагц сэнгэнэсэн улаан занданы үнэр шиг (хийсвэр) – балын амт адил эелдэг зөөлөн урьхан зан ааль (хийсвэр) – уран гол шиг бие (бодит))** зэргээр төлөөлүүлж үзэж байна. Энэ нь ертөнцийн аливаа юмс үзэгдэл бодитойгоос хийсвэр лүү, хийсвэрээс бодитой руу буюу өөрөөр хэлвэл ерөнхийгээс тусгай, тусгайгаас ерөнхий рүү гэсэн харилцан хамаарлын үүднээс шилжин хувирах, мөнхийн хөдөлгөөнд оршин байх тэрхүү зүй тогтлыг харуулж байгаа хэрэг юм. Нэгэнтээ нэрт сэтгэгч, гүн ухаантан З.Агваанбалдангийн өгүүлсэнчилэн: “... бодит юмс, үзэгдлийн өөрийн нь хувьсамхай чанарыг хоосон чанар, хүний сэтгэлийн үзэгдэл мөн.” (1978.31) хэмээсэн нь дээрхийг өгүүлсэн гэлтэй.

Ер нь хүслийн гэм болоод хурьцлын нисваанисаар хүмүүний ертөнц хийгээд жаргал, зовлонгийн утга учир оршино хэмээх үзэлтийг, илбэ зүүдний явдлаар урнаар дүрслэн үзүүлэх уламжлал гагц Ноён хутагтын уран бүтээлд төдийгүй Монгол, Дорно дахины бичиг зохиол, судар шистирын зүйлд нийтлэг байсан төдийгүй их зохиолч В.Инжаннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд өгүүлсэн байдгийг бид мэднэ. В.Инжаннаши “Улаанаа ухилах танхим” романдаа, хурьцлын нисваанисаас үүдэгдсэн хүний хорвоогийн хоосныг илбэ зүүдний үзэгдэл хуурмаг, “ус сарнин үүл тархаж, мөр төлөв үгүй болсонд буюу зүүдний доторхи зүүд шиг амьдралаар амьдрах...”-ын тухай өгүүлсэн нь эртний нанхиадын Күнз, Мэнзийн сургаал болоод Монголчуудын тэнгэр шүтлэгт нэвт суралцсаных нь тод илрэл болж зохиол бүтээлд нь тусгалаа олсны нэг л жишээ юм.

Дорно дахины ухаанд арга, билиг түүнийг бүүр лавшруулж нарийвчлан авч үздэг таван махбодын онолоор зурхай, яруу найраг, дуу хөгжим, хэл шинжлэл, гүн ухаан зэрэг таван ухааны хүрээнд чиглэл чиглэлээр нь юм юмны нэн гүнзгий далд учир утгад орчин цагийн шинжлэх ухаанаас ч түрүүлээд хүрч чадсан нь олонтой байдаг нь цаанаа арга, билгийн ухааны хүч чадлыг харуулна.

Ноён хутагтын “Үлэмжийн чанар” дууг арга, билгийн үүднээс авч үзвэл, арга хийгээд билиг, оюун ухаан хийгээд сэтгэл санааны чухам ямар тогтолцоон дээр зохиогдсон болох талаар, хамгийн чухал нь бүсгүй хүний гоо үзэсгэлэн хийгээд янаг амрагийн хөлгүй их амар жаргалангийн тухай өгүүлсэн мэт боловч угтаа бол тэнгэр газар лугаа арга, билгийн шүтэн барилдлага, хоосон хийгээд буй, бие хийгээд сэтгэлийн дуусашгүй төгс зохиролын үндсийг ертөнцөд оршихуйн үүднээс тайлбарлах нь илүү оновчтой мэт санагдана. Ингэж үзэх үндэс бол “Үлэмжийн чанар” дууны 1-р бадагт **үлэмж төгөлдөр өнгө тунамал толь шиг царайг** нүдээр харж, 2-р бадагт **хөхөөн эгшиг шиг эелдэг дууг хоолойг чихээр** сонсож, 3-р бадагт **учирмагц сэнгэнэсэн улаан занданы мэт үнэрийг хамраар** үнэрлэж, 4-р бадагт **балын амт адил баясгалант аалинд бүрнээ** автаж, 5-р бадагт **гоо бүсгүйн уран гол шиг биед хүрч улмаар хүрэлцэн мэдрэхийн цэнгэл** эдэлж хүмүүний орчлонгийн явдлыг учир шалтгааны дараалалтайгаар төгс өгүүлсэн байна. “Үлэмжийн чанар” дууны тухайд багахан судалгааны эцэст өгүүлэхэд:

Нэгдүгээрт: “Үлэмжийн чанар” дуу нь шалтгаан үрийг хамт боловсруулахдаа арга нь билгээсээ буюу сэтгэл санаа нь оюун ухаанаасаа давамгайлсан байдал илт ажиглагдаж байна.

Хоёрдугаарт: Оюун ухаан нь сэтгэл санаагаа жолоодох байгалийн хувиршгүй зүй тогтлыг баримтлахаасаа илүү өөрийн бодлыг зөвхөн өөртөө шингээж шүтэн барилдуулах чадвар нь оргилдоо хүрч чадсан Ноён хутагтын сэтгэл санаа давамгайлсан шүтэлцээний үрээс төрсөн бүтээл болох юм.

Гуравдугаарт: “Үлэмжийн чанар” дуу нь Ноён хутагтад зориулж өргөсөн гэх юм уу, хутагт өөрөө зохиосон ч гэх юм уу, юутай ч шашины үүрэг зорилгоор бүтээгдсэн гэхээсээ илүүтэйгээр янаг амрагийн сэдэвтэй, бүсгүй хүний үзэсгэлэн гоог магтан дуулсан иргэний чиг хандлага бүхий бүтээл ажээ.

Дөрөвдүгээрт: Шороо, ус, гал, хий дөрвөн махбодоос бүтсэн мэдэлгүй бодыг нүд, чих, хамар, хэл, бие эрхтнээр мэдэрч дүр төрх, дуу хоолой, үнэр, амт, хүрэлцэхүйн орноор сэрэгдэн хүртэгдэх хүмүний ертөнцийн жам ёсыг өгүүлсэн гүн ухааны өнгө аястай дуу юм.

НОМ ЗҮЙ

1. Ч.Алтангэрэл (1967), *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл*, Улаанбаатар.
2. Д.Баатар (1993), *Тавдугаар догшин ноён хутагт Равжайн цэди*, Сайншанд.
3. Ц.Дамдинсүрэн (1962), *Саран хөхөөний жүжгийн учир*, Улаанбаатар.
4. Ч.Жүгдэр (1978), *3.Агваанбалдангийн гүн ухааны үзэл*, Улаанбаатар.
5. В.Инжаннаши (1958), “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
6. Н.Ишжамц (1993), “Равжаа бус Равжай”, “Ил товчоо”, №33.
7. Г.Лхагвасүрэн (1993), *Ноён хутагт Данзанравжаа*, Улаанбаатар.
8. Д.Равжаа (1995), *Яруу найргийн цоморлиг*, (Д.Цагаан), Улаанбаатар.
9. Л.Хүрэлбаатар (1996), *Огторгуйн цагаан гарди*, Улаанбаатар.
10. Л.Хүрэлбаатар (2006), *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар.
11. Д.Цэрэнсодном (2000), *Эрдэнэ ноён хутагтын эш үзүүлсэн нэгэн сургаалын тухай*, “Культура Центральной Азии”, Выпуск 4. Улан-Удэ.
12. А.Шартолгой, Ш.Баяржаргал (2003), “Говийн ноён хутагт Лувсанданзанравжаа. Хутагтын амьдрал, он тооллын мөчлөг (1803-1856)”, Улаанбаатар.
13. Н.Поппе (1979), *Noyan Khutugtu Rabjai and Mongolian Folklore*, (Studia Sino-Mongolica, Wiesbaden).

SUMMARY

The works of Noyon Khutugtu Danzanravjaa's enjoy an important status within Mongolian classical literature studies. His song “Ulemjiin Chanar” (“Abundant Qualities”), which has been transmitted over many generations to the point of becoming identified as a folk song, poetically eulogizes the beauty of a woman from the perspective of the paccakāmaguṃa (pleasure of five senses).